



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/148

Бат-Өлзий сум

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын 3-р багийн Өвт-900 тоот нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Г.Дорждэрэм эзэнтэй "Аргалант" хүнсний дэлгүүрийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрөөс 3 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (нэг зуун мянга) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, (Д.Энх-Амгалан цагдаагийн хошууч), татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Э.Бадамханд) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

6223012

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/